

## ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2024 оны II улирлын түүвэр судалгааны тайлан)

### Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2024 оны 5-р сарын 20-оос 6-р сарын 3-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны байгууллагуудын нийт 20 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

### Шинжээчид:

#### 2024 оны II улиралд

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 6.8%,
- Эдийн засгийн өсөлт 7.0%,
- Бодлогын хүү 11.1%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.8% байна гэж таамагласан байна.

#### 2025 оны I улиралд

- Инфляц нэмэгдэж 7.6%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.6%,
- Бодлогын хүү 11.1%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.5% болно гэж таамагласан байна.

### Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2024 он 4 сар	2024 он II улирал	2025 оны I улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	6.1%	6.8%	7.6%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	7.8%*	7.0%	6.6%
Төв банкны бодлогын хүү /%/	12.0%	11.1%	11.1%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.2%	16.8%	16.5%

\* 2024 оны I улирал


Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2024

## I. Инфляц


2024 оны I улиралд Улаанбаатар хотын жилийн инфляц 6.1% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 2.4 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2024 оны II улиралд инфляц 6.8%, жилийн дараа 7.6% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

**Зураг 1. Инфляцын таамаглал**




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны II улиралд инфляц 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 36.2%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны II улиралд инфляц 8.0-8.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.4% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

**Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2024 оны II улирал/**




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурсан хэдий ч цаашид бага зэрэг өсөх хандлагатай байна. Шинжээчид 2024 оны II улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 8.8% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.8% гэж таамаглажээ (Зураг 3).

**Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт**



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.6-7.1% орчимд байна (Зураг 4).


**Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2024 оны II улирал/**



## II. Эдийн засгийн өсөлт


2024 оны I улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 7.8% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 1.0 нэгж хувиар өндөр гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2024 оны II улиралд 7.0%, 2025 оны I улиралд 6.6% гэж таамаглаж байна (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны II улиралд 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.9% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны II улиралд өсөлт 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 25.2% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2024 оны II улирал/




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад өсөх хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2024 оны II улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 6.6%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 7.0% байна гэж таамаглажээ (Зураг 7).

Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.6-7.0% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2024 оны II улирал/



### Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2024 оны II улиралд дунджаар 11.1%, хамгийн ихдээ 12.0%, хамгийн багадаа 10.0% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2025 оны I улиралд 11.1% байна гэж таамаглажээ (Зураг 9).

**Зураг 9. Бодлогын хүүний таамаглал**



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2024 оны II улиралд бодлогын хүү 11.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 10).


**Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2024 оны II улирал, хариултын тоогоор/**



2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг аажмаар нэмэгдүүлсээр мөн оны эцэст 13% хүргэсэн бол 2024 оны 3 сараас бодлогын хүүг бууруулж өнөөгийн байдлаар 11%-д хүргээд байна. Үүнтэй холбоотойгоор шинжээчдийн таамаглал огцом буурах хандлага ажиглагдлаа. Өмнөх

улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны II улирлын бодлогын хүүг 12.6% байна таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 11.1% байна гэж таамаглажээ (Зураг 11).


**Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**



### IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2024 оны II улиралд дунджаар 16.8%, хамгийн ихдээ 17.3%, хамгийн багадаа 15.0%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг буурч 2025 оны I улиралд 16.5% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

**Зураг 12. Зээлийн хүүний таамаглал**



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2024 оны II улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.6-17.0% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

**Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2024 оны II улирал, хариултын тоогоор/**



Зээлийн хүүний таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын үр дүнтэй харьцуулан авч үзвэл бага зэрэг нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. 2024 оны I улиралд шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нэмэгдсэнтэй

холбоотойгоор шинжээчдийн таамаглал мөн нэмэгджээ. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны II улиралд зээлийн хүүг 16.7% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.8% гарна гэж үзжээ (Зураг 14).

**Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**

